

1

**БНМАУ-ЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН УДСЫН ХОРОО,  
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ**

1991 оны I дүгээр  
сарын 09-ны өдөр

Дугаар. 02/01

Улаанбаатар  
хот

**Байгаль орчныг хамгаалах байгуул-  
лагыг өөрчлөн зохион байгуулах  
тухай**

**БНМАУ-ын Байгаль орчны хяналтын улсын хороо, Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:**

1. Улаанбаатар хотын Байгаль орчныг хамгаалах газрыг татан буулгасугай.

2. Нийслэл хотын нутаг дэвсгэр, Богд уул, ногоон бүсийн байгаль орчны хамгаалалтанд хяналт тавих, орчин зүйн өөрчлөлтийг судлах, тэнцвэрт байдлыг хангах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах үүрэгтэй Байгаль орчны хяналтын газрыг байгуулсугай.

3. Байгаль орчныг хамгаалах газрын Богд уулын хамгаалалтын захиргааг Дархан цаазат Богдхаан уулын захиргаа болгон бие даалган хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны харъяалалд ажилдуулсугай.

4. Хотын орчин зүйн хяналтын материаллаг баазыг бэхжүүлэх, орчин зүйн тэнцвэрийг хангах, нөхөн сэргээхтэй холбогдсон арга хэмжээг тодорхой зорилго, дэс дараатай авч хэрэгжүүлэхийг хотын байгаль орчны хяналтын газар /н.Дагвадорж/-т даалгасугай.

5. Богд уулын хамгаалалтыг сайжруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай БНМАУ-ын Байгаль орчныг хамгаалах Яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1988 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 63/98 дугаар тогтоолын 5 дугаар заалт, 6 дугаар хавсралтаас бусад заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**БНМАУ-ЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН  
УДСЫН ХОРООНЫ ДАРГА**

/З.БАТЖАРГАЛ/

**УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-  
ГААНЫ ДАРГА**

/Л.ЭНЭБИШ/